



Нэгдсэн Үндэстний Байгууллага 2026 оныг Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн Олон улсын жил болгон зарлалаа

2022 оны 3 сарын 15-нд Нью-Йорк хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей (НҮБ ҮА) дуу нэгтэйгээр 2026 оныг Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн Олон улсын жил (БНМОЖ) болгох шийдвэрээ зарлалаа. Эцсийн шатны энэ шийдвэр нь сүүлийн хэдэн жилийн хугацаанд эгнээндээ 300 гаруй нүүдэлчдийн байгууллага, дэмжигчдийг, тухайлбал Олон Улсын Мал Аж Ахуйн судалгааны хүрээлэн (ILRI), НҮБ-ын хэд хэдэн төрөлжсөн байгууллагыг нэгтгэсэн Олон улсын бэлчээрийн ба нүүдэлчдийн хөдөлгөөний оргил үр дүн болж байна. Эдгээр хүчин чармайлтанд тулгуурлан Монгол Улсын Засгийн Газар, дэмжлэг үзүүлсэн 60 улс орон НҮБ ҮА-д тогтоолын төслийг боловсруулан өргөн барьсан юм.

НҮБ ҮА-аас Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн Олон Улсын жилийн талаархи тогтоол нь биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, нийгэм-эдийн засгийн бүлэг асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэйг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байгаа гаа илэрхийллээ. Тогтоолын төсөлд зааснаар “нүүдийн мал аж ахуй нь экосистем, соёл, ялгаат байдал болон байгальтай зэрэгцэн орших уламжлалт мэдлэг, түүхэн туршлага бүхий динамик, шинэчлэн өөрчлөгч амьдралын хэв маяг мөн” хэмээжээ. Түүнчлэн “эрүүл, бүтээмжит бэлчээр нь малчдын эдийн засгийн өсөлт, амьжиргааны тогтвортой эх үүсвэр нь тогтвортой хөгжилд амин чухал” болохыг хүлээн зөвшөөрчээ. Тогтоол нь НҮБ ХХААБ-ыг 2026 онд БНМОЖ -ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажиллахыг хүссэн байна.

Бэлчээрийн эдэлбэр газар нь дэлхийн гадаргуугийн хагасаас илүү хувийг (одоогийн байдлаар эрдэмтдийн тогтоосноор 54%) эзлэх бөгөөд энэ нь дэлхийн хамгийн том, хамгийн их аюулд өртөмтэгэй, хамгийн бага хамгаалагдсан экосистем болж байна.

Дэлхий даяар бэлчээр нь олон зуун сая малчдын амьжиргааны эх үүсвэр, хүнс тэжээлийн баталгаа нь болж ирсэн ба хүнс тэжээлээр

зөвхөн өөрсдийгөө төдийгүй олон сая иргэдийг хангаж ирсэн. Нүүдэлчин малчид хүн суурьшаагүй зэлүүд нутаг, богино настай тачир сийрэг ургамлыг хэрэглэх замаар дотоодын болон экспортын зах зээлд хямд, эрүүл, өндөр уурагт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хүргэдэг.

Дэлхий даяраа урьдчилан таамаглахад бэрх, хувьсан өөрчлөгдөж буй уур амьсгалтай тулж, 700 гаруй сая буюу дэлхийн хүн амын аравны нэг нь хүнс тэжээлийн дутагдал, өлсгөлөнд нэрвэгдэж, сая гаруй төрөл зүйл ургамал амьтан хомсдолд орж байгаа өнөө үед бэлчээр болон малчдын тогтвортой удирдлага маш хэрэгтэй цагаа олсон шийдэл болж байна.

Сүүлийн нэг зуун жилд нүүдлийн ал аж ахуй эрхлэгчид олон янз шударга бус үйлдэлтэй нүүр тулах болсон. Тухайлбал, уламжлалт бэлчээрийн эдэлбэр газраасаа хөөгдөх, отор нүүдлийн замналаа хаалгах зэргийг дурьдаж болно. Гэсэн хэдий ч энэ нийгмийн бүлэг өнөөдөр бид бүхэнд тулгамдаад байгаа тодорхойгүй нөхцөл байдлыг үл ажиран өөрийн мэдлэг, чадвартаа тулгуурлан тогтвортой хөгжлийг эрэлхийлэн амьдарсаар байгаа билээ. Бэлчээрийн эдэлбэр газрын удирдлага болохын үүднээс малчид биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, өсгөн арвижуулах, нүүрс төрөгч шингээх, усан хагалбарыг хамгаалах зэрэг экосистемийн үйлчилгээгээр хангахад амин чухал үүрг гүйцэтгэсээр байна.

Аж үйлдвэржсэн, хязгаарлагдмал хүрээнд хөгжсөн эрчимжсэн мал аж ахуйн нүүрстөрөгс ялгаруулах хэмжээ, усны асуудалд үзүүлэх хувь нэмэр их байхад сүүлийн үеийн судалгаагаар бэлчээрийн мал аж ахуйн экологийн ул мөр тэгтэй тэнцэхийг баталсан байна. Нүүдэлчин малчдын ашиглаж буй бэлчээрийн эдэлбэр газар дэлхий дээрхи хамгийн том нүүрстөрөгч шингээгч экосистем болж байна. Бэлчээр ашиглалтыг тогтвортой арга хэлбэрээр хөтлөн явуулах нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чухал арга хэрэгсэл болно. Түүнчлэн мал аж ахуй бол хатуу түлшинд түшиглэсэн эрчим хүчний хэрэглээ багатай үйлдвэрлэлийн хэлбэр билээ. Газар ашиглалтын энэ хэлбэр байгалийн нөхөн сэргээгдэх нөөцөд тулгуурладаг төдийгүй байгалийн ургамлыг бүрэн ашиглах замаар ой, хээрийн түймээс ч урьдчилан сэргийлдэг давуу талтай. Иймээс бэлчээрийн мал аж ахуй нь экологийн цэвэр аж ахуйн хэлбэр бөгөөд хувьсамтгай өнөөгийн нөхцөлд үйлдвэрлэл ба тогтвортой байдлын хоорондын тэнцвэрийг хадгалах өндөр чадамжтай гэж дүгнэж байна.

Бэлчээр ба нүүдэлчдийн олон улсын жилийн зорилго нь эрүүл, бэтээмжит бэлчээр болон нүүдэлчин малчдын тогтвортой хөгжлийн талаархи олон нийтийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх, дэлхий даяар тогтсон мэдлэгийн орхигдлыг бууруулахад оршино. Энэ үйл явц нь мал

аж ахуйн салбарын чадавхийг дээшлүүлэх, энэ салбар дахь хариуцлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хүчин чармайлтаа чиглүүлнэ. Туйлын зорилго нь уур амьсгалын өөрчлөлт, ядуурал, биологийн олон янз байдалд учирч буй заналхийллийг бууруулах, хүнсний тогтвортой тогтолцоог бүрдүүлэх, Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг гүйцэлдүүлэх зэрэг олон янз улс төрийн хэлэлцүүлэгт бэлчээр болон малчдын байр суурийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд оршино. Бэлчээр ба нүүдэлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил нь эдгээр хэлэлцүүлгийн хүрээнд бэлчээрийн эдэлбэр газар, нүүдэлийн мал аж ахуйн үнэ цэнийн талаархи малчид болон эрдэмтдийн дуу хоолойг өндөрт хүргэхэд дэмжлэг болох нь дамжиггүй.

Холбоо барих

Мэриам Наймир-Фуллер
БНМОЖ Дэлхийн зохицуулах бүлгийн орлогч дарга
iyrp@iyrp.info

Энгин Илмаз, Йолда Санаачлага ба Газрын дундад тэнгисийн байгаль ба Соёлын Аллианс
БНМОЖ Дэлхийн зохицуулах бүлгийн гишүүн
+90 549 860 2766
engin@yolda.org.tr

Анн Ватерс-Байэр, Хөдөө аж ахуй ба экологийн Агрикол Ассоциаци
БНМОЖ Дэлхийн зохицуулах бүлгийн гишүүн
+49 551 485786
Waters-bayer@web.de

Нэмэлт мэдээлэл

БНМОУЖ-ийн тогтоолын хуулбарыг <http://undocs.org/en/A/76/L.36> хаягаас авна уу.

БНМОУЖ-ийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл www.iyrp.info хаягаас үзнэ үү.